

ХЯТАД:

ИЛИЯСИЖАН РЭХМЭН

ГЭР БҮЛЭЭСЭЭ ХАГАЦСАН НЬ

ЭРХИЙНХЭЭ
ТӨЛӨӨ
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНИЛ 



ИЛИЯСИЖАН РЭХМЭН

ХЯТАД

Илиясижан Рэхмэн болон түүний эхнэр Майриниша Абудуайни нар хоёр дахь хүүхдээ хүлээж байх үед Илиясижан сураггүй алга болов. Залуу хос үр хүүхдээ асрахын хажуугаар Египетэд их сургуульд суралцан шинэ ирээдүйг бүтээж байлаа. 2017 оны 7-р сард Хятад улс Египетийн засгийн газарт шахалт үзүүлэн тэнд амьдарч байсан олон зуун Уйгар иргэдийг цуглуулж, албадан гаргаснаар тэдний амьдрал орвонгоороо эргэсэн юм. Илиясижан тэдний нэг байв.

Нөхрөө сураггүй болох үед дөнгөж 19 настай байсан Майриниша гурван долоо хоногийн дараа 2 дахь хүүхдээ төрүүлсэн ба өнөөг хүртэл нөхрөө хайсаар байна.

Майриниша одоо Турк улсад амьдарч байгаа ба нөхрийг нь Хятадын Шинжаан руу буцаасан тухай найз нөхдөөсөө олж мэдсэн юм. Хятадын засгийн газраас Уйгар иргэдийн тархийг угаах суртал ухуулга хийдэг нууцаар хорих лагерийн аль нэгэнд нөхрийгөө байгаа хэмээн таамаглаж байна.

Нэг сая орчим иргэд энэ мэтээр гэр бүлээсээ хагацан эдгээр лагериудад хоригдож байгаа ба тэдний дийлэнх нь мусальман шашинтнууд аж. Майриниша нөхрөө гэр бүлдээ, үр хүүхдэдээ эсэн мэнд эргэж ирэхийг л хүсч байгаа. "Нөхрийг минь хурдан суллах ёстой, хүүхдүүдэд маань аав нь хэрэгтэй шүү дээ, нөхрөө эргүүлж авчрах хүртлээ би хэзээ ч зогсохгүй" хэмээн тэр өгүүлсэн юм.

ХЯТАДЫН ЭРХ БАРИГЧ
НАРТ ХАНДАН ЗАХИДАЛ
БИЧИЦГЭЭЭ.

Илиясижан Рэхмэнийг
нэн даруй, ямар ч
нөхцөлгүйгээр суллахыг
шаардацгаая.

Xi Jinping

*President of the People's
Republic of China
Zhongnanhai,
Xichangan'jie
Xichengqu, Beijing Shi
100017
People's Republic of China*

Факс: +86 10 6238 1025
Цахим хаяг:
english@mail.gov.cn

ИЛИЯСИЖАНЫ ГЭР БҮЛД
ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ
ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ.

Майриниша Абудуайнийн
Mairinisha Abuduaini @
munzira717 твиттер хаягаар,
<https://www.facebook.com/mansura.elyas.9>,
фээсбүүкээр дэмжиж
байгаагаа илэрхийлэн
зурвас илгээгээрэй. Мөн
дараах хаягаар захидал
илгээх боломжтой:

Amnesty Turkey

Hacımimi Mh.
Kemeraltı Cd.
Ada Han No.31
Kat:2 Daire:2
34425 Karaköy,
Beyoğlu/ISTANBUL
TURKEY

**ЗАХИДАЛ БИЧИЖ
ӨӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭЭ**

December 2019
Index: ASA 17/0752/2019 English
All images: (c) Private